



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/556

Номгон

Нэгдсэн эмнэлгийн Ковидын үеийн санхүүжилт,
хөрөнгө оруулалтын байдалд хяналт үнэлгээ хийх
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5 “а”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7¹ дүгээр зүйлийн 7¹.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.7, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Ковидын үеийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын байдалд хяналт үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Б.Наранбаяр - Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: Д.Даваажаргал – Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга

Гишүүд: Н.Батчимэг – Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын байцаагч

Г.Должинсүрэн – Санхүү, төрийн сангийн хэлтсийн Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн

М.Дүгэрмаа - Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн

А.Энхзаяа – Мэргэжлийн хяналтын газрын Эм биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч

А.Цэрмаа – Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга

Э.Баянзул – Онцгой байдлын газрын Ерөнхий нягтлан бодогч

Т.Гэрэлчулуун-Эрүүл мэндийн газрын Салбарын төсвийн төлөвлөлт, санхүүгийн бүртгэл мэдээлэл, тайлангийн нэгтгэл хариуцсан мэргэжилтэн

601210292

2.

П.Мөнх-Эрдэнэ – Эрүүл мэндийн газрын ерөнхий нягтлан бодогч

Г.Амарзаяа – Эрүүл мэндийн газрын Эх барих, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн


Н.Амараа – Эрүүл мэндийн газрын Эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин био бэлдмэлийн чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

2.Хяналт үнэлгээ хийх ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Удирдамжийн дагуу хяналт шалгалт явуулж, ажлын хэсгийн үнэлгээний дүн тайланг 2021 оны 09 дүгээр сарын 06-ны дотор аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох материалыг архивт шилжүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Б.Наранбаяр/-т үүрэг болгосугай.


4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг дарга 2021 оны 09
дүгээр сарын 03-ны өдрийн А/551 дүгээр
захирамжийг хавсралт



**АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН КОВИДЫН ҮЕИЙН САНХҮҮЖИЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРЦУУЛАЛТЫН БАЙДАЛД ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ**

Үндэслэл:

Аймгийн хэмжээнд “Ковид-19” цар тахлын нөхцөл байдал хүндэрч, тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний ачаалал ихэсч, цаашид үйл ажиллагаа доголдох, төсөв санхүүгийн байдалд эрсдэл учрах болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх шаардлага урган гарч байна.

Зорилго:

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Ковидын үеийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, зарцуулалтын байдалд хяналт, шалгалт явуулах, ковидын үеийн санхүүжилтыг үр ашигтай зарцуулах, улмаар эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

Хяналт үнэлгээний чиглэл:

- 1.Аймгийн онцгой комиссын хөрөнгө оруулалт, түүний зарцуулалт
- 2.Аймгийн Засаг даргын нөөцөөс хийгдсэн хөрөнгө оруулалт, түүний зарцуулалт
- 3.Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалт, түүний зарцуулалт
- 4.Олон улсын байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын хандив тусламж, түүний зарцуулалт
- 5.Эрүүл мэндийн даатгалын сангаас хийгдэж байгаа Ковидын үеийн эмчилгээний санхүүжилт, зарцуулалтын байдал

Хамрах хүрээ: Нэгдсэн эмнэлэг

Хугацаа: 2021 оны 09 дүгээр сарын 03-06-ны өдрүүдэд.

Тайлагнах: Аймгийн Засаг даргад 2021 оны 09 дүгээр сарын 06-нд танилцуулах